

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**ТӨСВИЙГ ҮР АШИГТАЙ, ХЭМНЭЛТЭЙ БАЙХААР УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

**ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ**

АУДИТЫН КОД: ДОА-2022/19-5-НА-СТА

Чойбалсан хот 2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: Ouyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Дүрслэлийн товъёог	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
Ерөнхий мэдээлэл	5

БҮЛЭГ 1. БАЯНТҮМЭН, ХӨЛӨНБУЙР, СЭРГЭЛЭН СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ СЕХ-НООС ӨГСӨН АРГАЧЛАЛ, ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА..... 6

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫГ БАТЛАГДСАН ТӨСВИЙН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА..... 7

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ТАЙЛАГНАСАН БАЙНА..... 8

ДҮГНЭЛТ: 9

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ХАРИУ ТАЙЛБАР:9

ЗӨВЛӨМЖ:10

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Батлагдсан төсөө эдийн засгийн ангиллаар.	6
Дүрслэл 2	Зардлын гүйцэтгэл аймаг, сумдаар.	7
Хүснэгт 1	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл.	8

	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д “Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана” гэж заасныг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд: • Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх; • Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлыг хууль, журам, зориулалтын дагуу зарцуулсан эсэх; • Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аймгийн болон 3 сумдын сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	АДБОУС-100, АДБОУС-200, АДБОУС-2000, АДБОУС-4000.16-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-4:2020 “Төрийн аудит, Санхүүгийн аудитын тулгуур зарчим”, АДБОУС-1000-1810 “Санхүүгийн аудитын удирдамж”, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журмыг баримтлан гүйцэтгэсэн бөгөөд дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүгнэлт боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Б.Оюунхэрлэн нар хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрөөс эхлүүлж, тайланг УАГ-ын аудитын 2 дугаар газар болон аймгийн Сонгуулийн хороонд 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдөр хүргүүллээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна.

Энэ хуулийн дагуу Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдад зохион байгуулагдах орон нутгийн хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах сонгуулийн хороог Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 9/02 дугаар тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүдтэй нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын 2022 оны нөхөн сонгуулийг 3 хэсгийн хороодтой зохион байгуулж, тэдгээрт ажиллах 39 төрийн албан хаагч ажилтан томилогдон ажилласан байна.

Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын нөхөн сонгуульд санал өгөх сонгогчийн нэрийн жагсаалтад 1286 сонгогч бүртгэлтэй байгаагаас санал хураалтад нийт 587 сонгогч буюу иргэдийн 45.6 хувь нь саналаа өгсөн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос Дорнод аймгийн Сонгуулийн хороонд 1465 ширхэг саналын хуудас олгосноос 589 ширхэг буюу 40.2 хувь нь санал хураалтад зарцуулагдаж, 2 ширхэг саналын хуудсыг хүчингүй болж, 876 ширхэг саналын хуудас зарцуулагдаагүй үлдсэн байна.

Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд 22.9 сая төгрөг, 3 сумын хэсгийн хороодод 22.6 сая төгрөг, нийт 45.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.


БҮЛЭГ 1. Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг СЕХ-ноос ирүүлсэн аргачлал, зөвлөмж, чиглэлийн дагуу хуваарилсан байна.

СЕХ-ны даргын 2022 оны А/06 дугаар тушаалаар Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны төсвийг 45.5 сая төгрөгөөр баталсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн хуваарилсан байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах сумын сонгуулийн хорооны санхүүжилтийг олгохдоо СЕХ-ны ажлын албаны 2022 оны 3/51, 3/82 тоот албан бичгээр ирүүлсэн аргачлал, зөвлөмж, СЕХ-ны даргын 2022 оны А/17 дугаар захирамжийн дагуу төсвийг зардал тус бүрээр сумдад хуваарилан олгосон байна.

Дүрслэл 1. Батлагдсан төсөв эдийн засгийн ангиллаар.



Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.


СЕХ нь 45.5 сая төгрөгөөс аймгийн Сонгуулийн хороонд 22.9 сая төгрөг, Баянтүмэн сумын Сонгуулийн хороонд 7.4 сая төгрөг, Сэргэлэн, Хөлөнбуйр сумын Сонгуулийн хороонд 7.6 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна. Үүнээс:

Урамшуулал, хоолны зардалд 24.5 сая төгрөг буюу 53.8 хувийг, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх, томилолт бусад унааны зардалд 13.2 сая төгрөг буюу 29.0 хувийг бичиг хэрэг, шуудан холбоо, сургалтын зардалд 3.2 сая төгрөг буюу 7.0 хувийг, үлдэх 4.6 сая төгрөг буюу 10.2 хувийг бусад зардлуудад хуваарилжээ.

БҮЛЭГ 2. Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна.

Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумын 2022 оны нөхөн сонгуулийн зардалд улсын төсвөөс хуваарилсан 45.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч зарцуулсан байна.

Дүрслэл 2.Зардлын гүйцэтгэл аймаг, сумдаар. /сая.төгрөгөөр/



Аймгийн сонгуулийн хороо 22.9 сая төгрөг, Баянтүмэн сумын сонгуулийн хороо 7.4 сая төгрөг, Сэргэлэн, Хөлөнбуйр сумын сонгуулийн хороо тус бүр 7.6 сая төгрөг, нийт 45.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн мэдээ, дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгахад анхан шатны баримтгүй, зардал хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил илрээгүй.

Харин болзошгүй зардалд төлөвлөгдсөн 1.5 сая төгрөгөөр “Honda” маркийн 6 ширхэг моторыг “Дорнын дэвшил” ХХК-тай тоног төхөөрөмж түрээслэх түрээсийн гэрээ байгуулан зарцуулсан байна. Гэвч уг “Honda” маркийн 6 ширхэг моторыг ашиглах хэрэгцээ шаардлага үүсээгүй байна.

Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг татан тулган шалгахад ашиглах боломжтой 5 ширхэг мотор байна. Иймд төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар удирдан зохион байгуулж, болзошгүй зардалд төлөвлөгдсөн 1.5 сая төгрөгийг хэмнэн улсын төсөвт буцаан төвлөрүүлэх боломжтой байсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх”, 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах” гэж заасан төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх зарчимтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Хүснэгт 1: Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Хуваарилагдсан зардлын ангилал	Хуваарилагдсан төсөв	Гүйцэтгэл	хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	150,000.00	150,000.00	0.3
2	Үнэмлэх хэвлэх зардал	150,000.00	150,000.00	0.3
3	Бичиг хэргийн зардал	1,050,000.00	1,050,000.00	2.3
4	Шуудан, холбооны зардал	1,250,000.00	1,250,000.00	2.7
5	Унааны зардал	3,780,000.00	3,780,000.00	8.3
6	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	520,000.00	520,000.00	1.1
7	МТБ, даамлын сургалтын зардал	60,000.00	60,000.00	0.1
8	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	260,000.00	260,000.00	0.6
9	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	900,000.00	900,000.00	2.0
10	Сурталчилгааны зардал	2,000,000.00	2,000,000.00	4.4
11	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	5,833,000.00	5,833,000.00	12.8
12	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	240,000.00	240,000.00	0.5
13	Томилолтын зардал	3,121,000.00	3,121,000.00	6.9
14	Мэдээ дамжуулах унааны зардал	210,000.00	210,000.00	0.5
15	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	20,680,000.00	20,680,000.00	45.5
16	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,760,000.00	3,760,000.00	8.3
17	Болзошгүй зардал	1,500,000.00	1,500,000.00	3.3
Нийт дүн		45,464,000.00	45,464,000.00	100.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

БҮЛЭГ 3. Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна.

Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аймгийн Сонгуулийн хороо 22.9 сая төгрөг, Баянтүмэн сумын сонгуулийн хороо 7.4 сая төгрөг, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын хороо тус бүр 7.6 сая төгрөг, нийт 45.5 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч хяналтыг тавьж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэж хуульчилсан.

Аудитаар аймгийн болон Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын Сонгуулийн хорооны 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Шилэн дансны цахим сайтад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 48.5 сая төгрөгийн 3 гүйлгээг аймгийн сонгуулийн хороо, 12.5 сая төгрөгийн 2 гүйлгээг Баянтүмэн сумын сонгуулийн хороо, 13.1 сая төгрөгийн 2 гүйлгээг Сэргэлэн сумын сонгуулийн хороо, 13.0 сая төгрөгийн 2 гүйлгээг Хөлөнбуйр сумын сонгуулийн хороо байршуулаагүй байсныг аудитын явцад нийт 87.1 сая төгрөгийн 9 гүйлгээг мэдээлүүлж ажилласан.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг СЕХ-ноос ирүүлсэн аргачлал, зөвлөмж, чиглэлийн хуваарилсан байна.
2. Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна.
3. Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна.
4. Төсвийг үр ашигтай, хэмнэлтэй ажиллахаар удирдан зохион байгуулж, болзошгүй зардалд төлөвлөгдсөн 1.5 сая төгрөгийг хэмнэн улсын төсөвт буцаан төвлөрүүлэх боломж байсан байна.
5. Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч хяналтыг тавьж ажилласан байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР:


**ДОРНОД АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
21000, Чойбалсан, Дорнод аймаг,
Утас/ факс: 7058-4681
2022-07-08 № 15
Танай _____ -ны № _____ -т

Л. Ирииндал
Мөнхсайхан
Дорнод аймгийн
Хурлын дарга
Батмөнх
2022.07.08

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА**

Аймаг, нийслэл, сум дүүргийн 2022 оны нөхөн сонгуулийн аймаг, сумын сонгуулийн хорооны зардлын тайланд хийсэн аудитын асуудлын бүртгэлтэй танилцлаа.

Төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.


**СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ДАРГА П.БАТ-ӨЛЗИЙ**

010620063

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах зөвлөмжийг өгч байна.

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлж байх.
2. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан төсвийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг баримтлан ажиллаж байх.

Аудитаар нийт 88.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад нийт 87.1 сая төгрөгийн орлого, зарлагын 9 гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлүүлж, 1.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгч ажиллаа.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 7 сарын 08 өдөр

Дугаар А/15

Чойбалсан хот

Г

Г

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсүгэй.
4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Д.Нармандах-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010073

Тэргүүлэх аудиторын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1/5 тоот тушаалын хавсралт

№	Байгууллагын нэр	Аудитын дугаар	Төлбөрийн актын утга	Мөнгөн дүн /мян төгрөг/
1	Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл	ДОА-2022/19-5-НА-СТА	Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд ашиглах боломжтой 5 ширхэг мотор байхад 1.5 сая төгрөгөөр "Honda" маркийн 6 ширхэг моторыг түрээслэх гэрээ байгуулж, төлбөрийг шилжүүлж төсвийг үр ашиггүй зарцуулсан	1,500.0
Нийт дүн				1,500.0

